



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 07 сарын 05 өдөр

Дугаар А/362

Булган

Гүйцэтгэгчид гэрээ байгуулах  
эрх олгох тухай

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгагдсан Дашинчилэн, Сайхан, Могод, Рашаант суманд хөв цөөрөм байгуулах ажлын зураг төсөл боловсруулах ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2017 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн зөвлөмжийн дагуу гүйцэтгэгчээр шалгарсан “Жишиг проект” ХХК-тай 22,950,600 /хорин хоёр сая есөн зуун тавин мянга зургаан зуу/ төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Байгаль орчин, аялал жуулчлалын газар /А.Гантөмөр/-т олгосугай.

2. Дээрх ажлын гүйцэтгэгчтэй холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд гэрээ байгуулж, гүйцэтгэж буй ажилд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар /А.Гантөмөр/-т үүрэг болгосугай.

3. Гэрээний хугацаанд дээрх ажлыг холбогдох хууль, журам, стандартын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг “Жишиг проект” ХХК /Ш.Даваажамц/-д даалгасугай.

4. Энэхүү ажлын санхүүжилтыг холбогдох хууль, тогтоомж, гэрээний дагуу Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч /С.Цэдэнлхам/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



З.БАТЗОРИГ